

Хичээл № 1

Удиртгал хичээл

Сэдэв: “Дэлхийн хувцас загварын түүх, хөгжлийн чиг хандлага” хичээлийн зорилго, агуулга, ач холбогдол, хичээллэх арга хэлбэр

1. Хичээлийн зорилго, агуулга, ач холбогдол

Хувцас загвар зохион бүтээгч дизайнер мэргэжилтэн бэлтгэх сургалт явуулж буй коллеж, их дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт мэргэжлийн суурь мэдлэг олгох зорилго бүхий "Хувцасны түүх" хичээл тусгагдсан байдаг. Монгол Улсын их, дээд сургуулиудын хувьд энэхүү хичээлээр ихэвчлэн эртний нийгмийн үеэс эхлээд өнөө үе хүртэлх түүхэн цаг үеүд дэх улс үндэстнүүдийн хувцасыг түүхчилсэн байдлаар зааж ирсэн.

Гэвч техник технологи, мэдээлэлийн хэрэгсэлийн хөгжил улам бүр хурдацтай явагдаж буй өнөө үед аливаа нэгэн түүх өгүүлсэн мэдээлэлийг оюутнууд цаг хугацаа, орон зайнаас үл хамааран, хэрэгцээтэй мэдээлэлээ шаардлагатай үед нь богино хугацаанд олж мэдэх боломж улам бүр нэмэгдсээр байна. Иймд ирээдүйд ажиллах мэргэжилтнүүдэд энэ хичээл хэрэгтэй юу?, энэхүү хичээлээр юу заах вэ?, хэрхэн заах ёстой вэ? гэдгээ ахин эрэгцүүлж үзэх шаардлага бидний өмнө тулгараад байна. Иймээс бид "Хувцасны түүх" хичээлийг "Хувцас загварын түүх ба хөгжлийн чиг хандлага" болгон өөрчилж, агуулга болоод, арга зүйн шинэчлэл хийж байгаа билээ. Магистрын төвшинд агуулгын хувьд Өнгөрсөн-Одоо-Ирээдүй гэсэн зарчмын дагуу баяжуулалт хийж байгаа ба арга зүйн хувьд суралцагчдын идэвхитэй оролцоог бүрдүүлэх, асуудал дэвшүүлэх, багаар ажиллах, бүтээлч сэтгэлгээг нь хөгжүүлэх, нээн илрүүлэхэд чиглэсэн аргуудыг ашиглах, мөн хичээл хоорондын уялдаа холбоог хангахад анхаарч байна.

- Хичээлийн цөм агуулга:

1. Эртний гар урлалын үеийн хувцасны загварыг судлах нь дизайнер мэргэжилтнүүдэд ямар хэрэгтэй болох тухай,
2. Аж үйлдвэржилтээс өмнөх үеийн буюу гар урлалын үеийн хувцасны загварын шийдэл, урлан бүтээж байсан арга техник тэдгээрийн бусад улс оронд хэрхэн тархаж байсан тухай.
3. Аж үйлдвэрийн 1, 2, 3 дугаар хувьсгалын үеийн хувцасны загварын үйлдвэрлэл, улс орнуудын харилцаа холбоо, техник технологийн дэвшлүүд загварын тархалтад хэрхэн нөлөөлсөн тухай,
4. Одоогийн загварын салбарын хөгжлийн хүрсэн төвшин, загварын чиг хандлагууд,

5. Ирээдүйд хүмүүсийн загварын хэрэгцээ, дизайнер мэргэжилтнүүдэд тавигдах шаардлага хэрхэн өөрчлөгдөж байгаа тухай зэрэг болно.

- Хичээл хоорондын уялдаа холбоо, арга хэлбэр:

"Хувцас загварын түүх ба хөгжлийн чиг хандлага" хичээл нь "Хувцасны загвар зураг", "Бүтээлч сэтгэлгээний арга зүй", "Уран бүтээлийн дадлага-1", "Уран бүтээлийн дадлага-2" хичээлүүдтэй уялдаж явагдах тул оюутнуудад олон талын ойлголт, мэдлэг, сэтгэлгээний ур чадвар, баг хамт олноор ажиллах туршлага олгогдох ач холбогдолтой.

Хувцас анх хамгаалах үүрэгтэй (хүйтэн, халуун, ус чийг гэх мэт орчны тааламжгүй нөлөөлөлөөс гадна бусад хэд хэдэн хамгаалах хүчин зүйлүүд байдаг. Энэ талаар цаашид нарийвчлан ярилцах болно) үүсч улмаар, түүхэн цаг үеийн хэрэгцээ шаардлагын дагуу гоо сайхны, эрүүл ахуйн, эргономикийн, эдийн засгийн, техик технологийн, дохиолон мэдээлэх гэх мэт үүргүүд нэмэгдэж нийгмийн байдлаас шалтгаалан байнга хувьсан өөрчлөгдөж ирсэн. Өөрөөр хэлбэл, хувцас загварын хувьсал өөрчлөлт нь тухайн үеийн нийгмийн үзэл санаа, хөгжил дэвшил, түүний үр дагаварын бодит илэрхийлэл болох хүмүүний амьдралд гарсан өөрчлөлттэй салшгүй холбоотойгоор хувьсан хөгжсөөр өнөөдрийг хүрчээ. Үүнийг олон улс орны үндэсний хувцас, түүний хувьсал өөрчлөлт, өнөөгийн хэрэглээнээс харж ойлгож болно.

Хувцас үүсч хөгжиж ирсэн түүхээс үзвэл XVIII зуун буюу аж үйлдвэржилтийн үе хүртэл хувцас нь гар урлалын бүтээл байсан ба нийгмийн анги давхарга, үндэстэн угсаатны ялгаа, хөрөнгө чинээний байдлыг хувцаснаас хараад тодорхойлж болдог байсан бол аж үйлдвэржилтийн үйл явц эхэлсэнээр хувцасаар илэрхийлэгдэх шинж тэмдгүүд аажмаар бүдгэрч хувцас загвар ардчилсан шинжтэй болжээ. Эндээс бид технологийн хөгжил дэвшлийн нөлөөлөлийн хүчийг олж харж байна. Тэгэхээр, ирээдүйд хувцас хэрхэн хөгжихийг тааж хэлэхэд тийм ч амар биш болох нь ойлгогдож байна. Ямартай ч өнгөрсөн түүх, одоогийн хөгжил, ирээдүйн хандлагыг судлах нь дизайнерүүдийн зайлшгүй ажил гэдэг нь ойлгомжтой байгаа тул хичээлийн зорилго үүнд чиглэгдэнэ.

Дизайнерүүд амжилтанд хүрэхийн тулд хувцасыг антропологи, түүх, урлаг, техник технологи- үйлдвэржилт, зах зээл, сэтгэл судлал, ирээдүй судлал гэх мэт олон салбар чиглэлээр судлах шаардлагатай болдог. Ялангуяа, техик технологийн хөгжлийн хурд тасралтгүй өсөн нэмэгдэж буй өнөө үед бид өнгөрсөн-одоо-ирээдүйн хувцасны талаар цэгцтэй (системтэй) мэдлэг, мэдээлэл хуримтлуулах, боловсруулах,

түүнийгээ мэргэжлийн үйл ажиллагаандаа бүтээлчээр ашиглах нь өнөөгийн дизайнерүүдэд улам их шаардагддаг болж байгаад хичээлийн бас нэгэн ач холбогдол оршино.

Хичээлийн үндсэн сэдэвт орохын өмнө хувцасыг олон янзаар нэрлэн тодорхойлж ирсэн байдгийг эргэн санъя. Миний хувьд хамгийн өргөн утга агуулгатай, нийтлэг хэрэглэгддэг нэр томъёо бол **“Костюм”** гэж үздэг. Иймээс энэ нэр томъёоны талаар товч тайлбар хийе.

“Костюм” гэдэг нь франц хэлний “загвар, заншил” гэсэн үгнээс гаралтай нэр томъё бөгөөд аливаа хувь хүний хийгээд ямар нэг бүлгийн нийгэмд эзлэх байр суурь, анги давхарга, нас хүйс, ажил мэргэжил, гоо сайхны таашаал сонирхол, тэр бүү хэл түүхт эрин үеийн онцлог шинжүүдийг ч тусган илэрхийлж байдаг хувцаслалтын өвөрмөц хэв маягийг илэрхийлдэг. Мөн урлаг спортын, усны, бүжгийн, үдэшлэгийн, хуримын хувцас гэх мэт тодорхой үйл ажиллагаанд тохирсон хэрэглээний хувцасыг тодорхойлоход ч хэрэглэгддэг.

Түүнчлэн, үндэсний хувцас эсвэл бүс нутгийн хувцас нь тухай тухайн орон нутгийн өвөрмөц байдал төдийгүй соёлын өвөрмөц шинж чанарыг онцлон илэрхийлдэг. Энэ утгаараа аливаа нэгэн улсын үндэсний бахархал болох нь ч бий. Үүнийг бид өөрийн үндэсний хувцасны уламжлалыг судлан мэдэж болно. Жишээлбэл, монгол үндэсний хувцас бол монголчуудын үндэсний бахархал, төрийн өмсгөл болж байдгийг бид цагаан сар, улсын баяр наадам төдийгүй монголчуудын хуримын ёс заншлаас олж харж болно. Жишээлбэл, Үзэмчинд ...Хүүхэн хүн харьд мордож хүрсэн тэр мөчид хадмын талаас төрийн ёсоор шинэ бэрдээ ууж өмсүүлэн, татуур, малгай шагнаж, гэрийн эзэгтэй болсныг нь мэдээлэн, тэнгэр бурхан, аав ээждээ мөргөж, хар үсээ хагалаж, хаан төрийн ёсоор бэр болсныг нь баталдаг билээ. Иймээс уужийг хаан төрийн хувцас гэж нэрлэн хүндэтгэдэг. Төрийн хувцас болох уужийг өмссөн бэр ямар нэг шалтгаанаар ураг салахад хүрвэл хадмын тал нь төрийн уужийг нь авч үлдэн дараагийн бэр болох бүсгүйд залган өмсүүлж хуримын ёсоо гүйцэтгэдэг. Ер нь бүсгүй* болоод олон ууж хийж өмсдөг ч гагцхүү хадмын талаас хуримын ёслолд зориулж өгсөн уужийг буцаадаг заншилтай. Учир нь энэ уужыг үе уламжлан бэр буулгахад хэрэглэн, өвөг дээдсийн хөрөнгө болгон хадгалдаг...¹

¹ Ариунаа Т. Үзэмчин ястны уламжлалт өмсгал, зүүтгэл, эд хэрэгчүүгээрлэл.- УБ.: Маршал принт, 2014.- Х.34-35.


* **бүсгүй** – монголчууд гэрлэсэн эмэгтэйг ийнхүү нэрлэдэг. Харин гэрлээгүй залуу охидыг хүүхэн хэмээн нэрлэдэг байсан ч одоогийн хүмүүс энэ хоёр нэрийг адил утгаар ойлгон хэрэглэж байгаа нь ташаа үзэгдэл гэж үзэж болно.

заншил байдаг ажээ. Энэ нь монголчуудын хувьд үндэсний хувцас нь ямар их утга агуулгыг тээсэн эрхэм зүйл болохыг илтгэж байгаа хэрэг юм.

2. Хичээллэх арга хэлбэр

“Кроссенс” буюу “Утгын сүлжээ” гэдэг идэвхитэй сургалтын аргаар хичээллэнэ. Энэ аргын тухай видео хичээлээр “Монгол малгай” гэсэн кроссенсийн жишээн дээр тайлбарлах болно. Цаашид бид **кроссенс** гэдгийг **утгын сүлжээ** гэсэн монгол үгээр нэрлэж занших нь зүйтэй болов уу!

МОНГОЛ МАЛГАЙ



Зорилго: *Монголчуудын малгайн үүсэл, хувьсал хөгжлийг судлах арга зүйд хөтлөх*

Цэвээндорж Д. Монголын эртний урлагийн түүх. УБ., 1999

Баяр Д. Монгол нутаг дахь хүн чулуун хөшөө.- УБ., 2001.

Баяр Д. Монголчуудын чулуун хөрөг.- УБ., 2002.- 256х.

Мөнхцэцэг Б. Хүннүд холбогдох хувцасны төрөл зүйлийн судалгаа.- УБ., 2013.